



**ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ
АВТОЗАМЫН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН**

2025.07.26

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго

Зам, тээврийн яамны Авто замын бодлого зохицуулалтын газар /АЗБЗГ/-ын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”, “Үнэлгээ хийх журам”, “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/87 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг үндэслэл болгосон.

Хоёр. Танилцуулга

ЗТЯ-ны Авто замын бодлого зохицуулалтын газрын 2025 оны эхний хагас жилийн үйл ажиллагааг Газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлт, Нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний биелэлт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Сайдын тушаалын биелэлт, ТНБД-ын тушаалын биелэлт, Ил тод байдлын үнэлгээ гэсэн 8 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр 69.4 %-тай байна. Эдгээрийг тус тусад нь авч үзвэл:

2.1. Авто замын бодлого зохицуулалтын газрын 2025 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил, үйлчилгээний хэрэгжилтийн байдлыг доорх хүснэгтэд үзүүлэв.

Нийт заалт	Үүнээс						Хугацаа болоогүй	Биелэлтийн хувь
	100%	90%	70%	50%	30%	0%		
88	40	17	9	10	6	2	4	81.4

2.2. МУ-ын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт дараах байдалтай байна.

Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн явц зорилтот түвшин				Хэрэгжилтийн хувь
	85 хувь буюу түүнээс дээш “үр дүнтэй”	60-84 хувь буюу “үр дүн хүлээгдэж байгаа”	30-59 хувь буюу “үр дүн хангалтгүй”	0-29 хувь буюу “үр дүн гараагүй”	
32	8	4	5	15	50.8

2.3. МУ-ын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлт дараах байдалтай байна

	Хэрэгжилтийн явц зорилтот түвшин	
--	----------------------------------	--



Арга хэмжээний тоо	85 хувь буюу түүнээс дээш “үр дүнтэй”	60-84 хувь буюу “үр дүн хүлээгдэж байгаа”	30-59 хувь буюу “үр дүн хангалтгүй”	0-29 хувь буюу “үр дүн гараагүй”	Хэрэгжилтийн хувь
38	9	-	4	25	41.9

2.4. Нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний биелэлт дараах байдалтай байна.

Нийт заалт	Үүнээс						Биелэлтийн хувь
	100%	90%	70%	50%	30%	0%	
10	1		4	4	1	-	61.0

2.5. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцыг дүгнэвэл:

Нийт заалт	Үүнээс				Биелэлтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
84	56	14	14	-	80.0

2.6. Сайдын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын биелэлт:

Нийт заалт	Үүнээс				Биелэлтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
48	35	12	1	-	74.5

2.7. ТНБД-ын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын биелэлт:

Нийт заалт	Үүнээс				Биелэлтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
57	34	18	5	-	65.4

2.8. Ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтүүдийн үнэлгээ:

Мэдээлэл	Нийт заалт	Үүнээс					Биелэлтийн хувь
		100%	70%	30%	0%	хамааралгүй	
Нийт	2	2	-	-	-	-	100.

Гурав. Үнэлэлт, дүгнэлт

3.1. Төлөвлөлтийн байдал:

3.1.1. АЗБЗГ-ын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт эхний хагас жилийн байдлаар дундаж үнэлгээ 81.4 хувьтай байна. Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан арга хэмжээний хэрэгжүүлэх хугацаа болон хүрэх түвшин нь яамны төлөвлөгөөнөөс хүрэх түвшин багассан, хэрэгжих хугацааг алдаатай төлөвлөсөн байна.

3.1.2. Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан 88 арга хэмжээнээс барилгын ажлын хувийг томъёолон тооцсон 57 арга хэмжээ байна. Бусад арга хэмжээ нь “гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу зорилт, арга хэмжээ тус бүрийг хувиар илэрхийлж дүгнэх тул төлөвлөгөөний суурь түвшин болон хүрэх түвшинг тоо нь утгаар илэрхийлэхүйц төлөвлөх” гэж заасны дагуу гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах шаардлагатай байна.

3.2. Хэрэгжилтийн байдал:

3.2.1. ЗТЯ-ны Авто замын бодлого зохицуулалтын газрын 2025 оны эхний хагас жилийн үйл ажиллагааг Газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлт, Нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний биелэлт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Сайдын тушаалын биелэлт, ТНБД-ын тушаалын биелэлт, Ил тод байдлын үнэлгээ гэсэн 8 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр 69.4 %-тай байна.

3.2.2. Авто замын бодлого зохицуулалтын газрын 2025 оны эхний хагас жилийн Газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хөрөнгийн асуудалтай болон хөрөнгө шийдэгдээгүй арга хэмжээнүүдийг бусад арга замаар хөрөнгө оруулалтыг шийдэх чиглэлээр идэвх санаачилгаатай ажиллах, 2025 оны төсвийн тодотголд хөрөнгийн асуудал шийдэгдээгүй, он дамжин хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн санхүүжилтийг бүрэн тусгуулах санал хүргүүлэх мөн төсөв хөрөнгө шаардлагагүй журам, норм норматив шинэчлэн боловсруулах, төлбөр хураах цэг цахимжуулах, үнэлгээний хорооны ажлыг эрчимжүүлэх чиглэлээр анхаарч, зорилтод түвшин болон төлөвлөсөн хугацаанд хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах шаардлагатай байна.

3.2.3. 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан 88 арга хэмжээний хэрэгжилт 81.4 % байна. Үүнээс 75% нь хүрэх түвшиндээ бүрэн хүрсэн болон хүрэх шатандаа, 25% нь төлөвлөсөн үр дүндээ бүрэн хүрээгүй байна.

3.2.4. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг зорилтуудаар нь авч үзвэл:

Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжил хувь
Зорилт 1: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2738.95 км /шилжих 1578.51 км, шинэ 1160.44 км авто зам, 1800.53 у/м /шилжих 878.93 у/м, шинэ 921.6 у/м гүүрийн нийт 50 төслийг хэрэгжүүлж, үүнээс шинээр 15 төслийн барилгын ажлыг эхлүүлнэ.	46	83.7
Зорилт 2: Гадаад зээлийн санхүүжилтээр 203 км авто замын барилгын ажлыг хэрэгжүүлж, 361 км авто зам, 1205 у/м гүүрийн их засварыг эхлүүлнэ.	22	75.0
Зорилт 3: Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд нийт 6 төслийн 1347.7 км /шилжих 447.7 км, шинэ 900 км/ авто зам барилгын ажлыг хэрэгжүүлнэ.	9	88.0
Зорилт 4: Олон улс, улсын чанартай 14,891.4 км авто замын бэлэн байдлыг хангуулж, нийт 3 чиглэлийн 183 км замын их засвар шинэчлэлтийн ажлыг эхлүүлж, 4 төслийн 618.35 км авто замын зураг төслийг боловсруулна.	7	80.0
Зорилт 5: Авто замын салбарын эрх зүйн орчин, стандарт, норм шинэчлэн сайжруулж, боловсронгуй болгоно.	4	85.0

3.2.5. Тус газар нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын 88 арга хэмжээ төлөвлөснөөс авто замын барилгын ажлыг үргэлжлүүлэх 35, тендер сонгон шалгаруулалт зарлан, барилгын ажлыг эхлүүлэх 22, шинээр авто замын барилгын

ажлыг эхлүүлэх 8, санхүүжилт шийдвэрлэх 5, авто зам ашиглалтад оруулах 4, журам боловсруулах 2, ТЭЗҮ боловсруулах 2, гэрээ байгуулах, зураг төсөл хүлээн авах, их засвар, урсгал засвар, ээлжит засвар хийх, пүү шинээр байршуулах, норм, норматив боловсруулах, төлбөр хураах цэг цахимжуулах, тэмдэг тэмдэглэгээ шинэчлэх зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

3.2.6. Зам, тээврийн яамны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тус газрын хэрэгжүүлэн ажиллах 14 арга хэмжээний дундаж хэрэгжилт 73.8 хувьтай үнэлэгдсэн байна. Яамны төлөвлөгөөнд туссан 14 арга хэмжээнээс хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай 3 арга хэмжээ байна. Үүнд:

Арга хэмжээ 3.2.2. Нутгийн зам төслийн хүрээнд сумдыг хатуу хучилттай авто замаар холбох барилгын ажлыг үргэлжлүүлнэ.

Зорилтод түвшин: 11 сумыг хатуу хучилттай авто замаар холбох нийт 484.56 км авто замын барилгын ажил хэрэгжинэ.

Биелэлт: 2025 оны 04 дүгээр сарын 01-нээс эхлүүлсэн бөгөөд барилгын ажил үргэлжилж байна.

Арга хэмжээ 3.4.3. "Монгол Улсын тээврийн холболт ба логистикийг сайжруулах төсөл"-ийн хүрээнд ээлжит болон их засварын ажлыг эхлүүлнэ.

Зорилтод түвшин: Авто зам, гүүрийн их засварын ажлын гүйцэтгэлийг 40 хувьд хүргэнэ.

Биелэлт: Багц 1: Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж 2025.06.04-ний өдөр гэрээ байгуулан ажлыг эхлүүлсэн. Багц 2: Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж 2025.05.27-ны өдөр гэрээ байгуулан ажлыг эхлүүлсэн. Багц 3: Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулах мэдэгдлийг 2025.06.23-ны өдөр хүргүүлсэн.

Арга хэмжээ 3.4.4. ЗГҮАХ-т туссан авто зам, гүүрийн ТЭЗҮ, зураг төслийг боловсруулах ажлыг үргэлжлүүлнэ.

Зорилтод түвшин: Нийт 4 төслийн 618.35 км авто замын зураг төслийг боловсруулж, магадлалын дүгнэлт гаргуулна.

Биелэлт: 2025 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТЭЗҮ, зураг төслийн саналыг ажлын даалгаврын хамт ЭЗХЯ-д хүргүүлсэн.

Дөрөв. Санал, зөвлөмж

4.1. Авто замын бодлого зохицуулалтын газрын 2025 оны эхний хагас жилийн Газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хөрөнгийн асуудалтай болон хөрөнгө шийдэгдээгүй арга хэмжээнүүдийг бусад арга замаар хөрөнгө оруулалтыг шийдэх чиглэлээр идэвх санаачилгаатай ажиллах, 2025 оны төсвийн тодотголд хөрөнгийн асуудал шийдэгдээгүй, он дамжин хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн санхүүжилтийг бүрэн тусгуулах санал хүргүүлэх мөн төсөв хөрөнгө шаардлагагүй журам, норм норматив шинэчлэн боловсруулах, төлбөр хураах цэг цахимжуулах, үнэлгээний хорооны ажлыг эрчимжүүлэх чиглэлээр анхаарах;

4.2. "Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тус газрын хариуцан хэрэгжүүлэх 32 арга хэмжээний дундаж хэрэгжилт 50.8 хувьтай, Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд туссан 38 арга хэмжээний дундаж хэрэгжилт 41.9 хувьтай, Нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээнд туссан 10 арга хэмжээний дундаж хэрэгжилт 61.0 хувьтай тус тус үнэлэгдсэн байна. Эдгээр бодлогын баримт бичиг, гэрээнд туссан томоохон төсөл хөтөлбөрүүд нь хөрөнгө оруулалт удаашралтай байдал болон зарим төсөл арга хэмжээ нь 2025 оны төсөвт суугаагүйгээс хэрэгжих боломжгүй болсон байна. Мөн бодлогын баримт бичигт туссан арга хэмжээний шалгуур үзүүлэлт болон зорилтод түвшин зөрүүтэй, зарим арга хэмжээний суурь түвшингүй зэрэг

хэрэгжилтийг тайлагнасан хүснэгт алдаатай байгаа нь арга хэмжээний дундаж үнэлгээ буурах гол нөхцөл болсон байна.

4.3. Автозамын бодлого зохицуулалтын газар нь бодлогын баримт бичигт туссан шалгуур үзүүлэлт, суурь түвшин, зорилтод түвшинд зэргийг нягтлан, алдаатай бичигдсэн арга хэмжээг засуулах, мөн хууль тогтоомж, тогтоол шийдвэр, сайдын болон төрийн нарийн бичгийн даргын тушаал өгөгдсөн үүрэг даалгаварт цаг хугацааны хувьд утга учир алдагдсан, үүрэг даалгавар давхардсан, биелэлтийг дутуу тайлагнасан, эсвэл арга хэмжээ бүрэн хэрэгжсэн ч хяналтаас хасагдаагүй байгаа зэрэг арга хэмжээнүүдийг Хяналт-шинжилгээ, дотоод аудитын газартай зөвшилцөж хяналтаас хасаж ажиллах;

4.4. Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам"-д заасны дагуу яамны төлөвлөгөө батлагдсан даруйд нэгжийн төлөвлөгөөг шинэчлэн батлуулж, шинэчлэн батлагдсан журамд заасны дагуу шалгуур үзүүлэлт болон зорилтод түвшинг боловсруулах;

4.5. Төрийн жинхэнэ албан хаагч бүр өөрийн хариуцсан ажлын биелэлтийг заасан хугацаанд, товч бөгөөд тоо баримттай, тогтмол үнэн зөвөөр тайлагнаж ажиллахыг тус тус зөвлөж байна.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР